



БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



Танаа

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

/2014 оны эхний 2 сар/

/албан ёсны статистик мэдээллээр бэлтгэсэн танилцуулга/



2014 он

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Жил бүрийн эхний 2 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2013	2014
Суурин хүн ам	Тоо	25875	26905	27036	27440	27936	
Төрөлт	Тоо	123	112	93	86	129	130
Нас баралт	Тоо	28	29	33	20	31	31
Шилжиж ирсэн	Тоо	156	293	123	134	340	163
Шилжиж явсан	Тоо	202	248	103	181	368	158
Ажилгүйчүүд	Тоо	497	813	773	1662	384	272
Халдварт өвчин	Тоо	115	85	125	87	121	53
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	45	42	32	58	45	48


АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2014 оны эхний 2 сарын байдлаар 18765.0 сая төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 5.2 хувиар буюу 926.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл


Үзүүлэлт	Нийт үйлдвэрлэл /биет хэмжээгээр/			Нийт үйлдвэрлэл /үнийн дүнгээр, мянган төгрөг/		
	2013 он	2014 он	өсөлт бууралт	2013 он	2014 он	өсөлт бууралт
Нүүрс олборлолт	819.1	788.6	-30.5	16791550.0	17743500.0	951950.0
Дулаан дамжуулалт	50.9	51.1	0.2	972229.0	935987.3	-36241.7
Талх үйлдвэрлэлт	10.0	11.3	1.3	12494.4	14474.8	1980.4
Нарийн боов үйлдвэрлэлт	18.3	22.9	4.6	62389.1	71070.4	8681.3

Тайлант хугацаанд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг /биет хэмжээгээр/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нарийн боов үйлдвэрлэл 25.1 хувиар буюу 4.6 тонноор, талх үйлдвэрлэл 13.0 хувиар буюу 1.3 тонноор, дулаан дамжуулалт 0.4 хувиар буюу 0.2 мянган гкал-аар тус тус өссөн бол нүүрс олборлолт 3.7 хувиар буюу 30.5 мянган тонноор буурсан байна.

Зураг 1. Нүүрс олборлолт




Зураг 2. Нүүрс олборлолт /сараар/



Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг үнийн дүнгээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд нүүрс олборлолт 5.7 хувиар буюу 951.9 сая төгрөгөөр, нарийн боов үйлдвэрлэлт 13.9 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр, талх үйлдвэрлэлт 15.9 хувиар буюу 2.0 сая төгрөгөөр тус тус өссөн бол, дулаан дамжуулалт 3.7 хувиар буюу 36.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.


Зураг 3. Талх, нарийн боов үйлдвэрлэл



НИЙГМИЙН ДААТГАЛ: 2014 оны эхний 2 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 1307.7 сая төгрөгт, зарлага 2598.0 сая төгрөгт хүрч, орлого нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 21.4 хувиар буюу 230.4 сая төгрөгөөр, зарлага нь 18.6 хувиар буюу 407.6 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Нийт орлогын 62.6 хувь буюу 819.3 сая төгрөгийг тэтгэврийн сангаас, 7.0 хувь буюу 91.4 сая төгрөгийг тэтгэмжийн сангаас, 1.7 хувь буюу 21.8 сая төгрөгийг ажилгүйдлийн сангаас, 8.1 хувь буюу 106.0 сая төгрөгийг ҮОМШӨ сангаас, 20.6 хувь буюу 269.2 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас тус тус төвлөрсөн байна.


Зураг 4. Нийгмийн даатгалын сангийн орлого /эхний 2 сар/



Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сан

Үзүүлэлт	2013 он		2014 он	
	Хүний тоо	Сая төгрөг	Хүний тоо	Сая төгрөг
Сангийн орлого бүгд		1077.3		1307.7
үүнээс: тэтгэврийн сан		673.1		819.3
тэтгэмжийн сан		76.0		91.4
ажилгүйдлийн сан		18.6		21.8
ҮОМШӨ-ний сан		88.2		106.0
ЭМД-ын сан		221.4		269.2
Сангийн зарлага бүгд	24538	2190.4	12901	2598.0
үүнээс: тэтгэврийн сан	3147	1496.7	3427	1674.2
тэтгэмжийн сан	330	74.2	431	90.6
ажилгүйдлийн сан	86	26.3	33	23.9
ҮОМШӨ-ний сан	475	292.8	399	292.1
ЭМД-ын сан	20500	300.4	8611	517.2


Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн зарлага /эхний 2 сар/



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 3427 хүнд 1674.2 сая төгрөгийн тэтгэвэр, 431 хүнд 90.6 сая төгрөгийн тэтгэмж, 399 хүнд 292.1 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 8611 хүнд 517.2 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгал, 33 хүнд 23.9 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ:

2014 оны эхний 2 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн 43.3 хувь нь буюу 242.4 сая төгрөг улсын төсвөөс, 55.4 хувь нь буюу 310.3 сая төгрөг орон нутгийн төсвөөс, 1.3 хувь нь буюу 6.8 сая төгрөг бусад орлогоос тус тус санхүүжигдсэн байна.

**Хүснэгт 3. Нийгмийн халамжийн сан**

Зураг 6. Нийт орлого - 559.5 сая төгрөг

Үзүүлэлт	2013 он		2014 он	
	Мян төг	Хүний тоо	Мян төг	Хүний тоо
Халамжийн сангийн орлого	559144.2		559528.0	
үүнээс: улсын төсвөөс	232800.0		242400.0	
орон нутгийн төсвөөс	310457.8		310295.0	
МУХС-аас олгосон санхүүжилт	15000.0		-	
бусад орлого	886.4		6833.0	
Халамжийн сангийн зарлага	477809.8		504211.8	
үүнээс: Тэтгэвэр	86176.8	544	127516.6	572
Тэтгэмж	28262.8	298	45002.2	321
Хүний хөгжил сан	21853.3	25	-	-
"Алдарт эх" 1 одонтой эхчүүд	146000.0	730	118600.0	593
"Алдарт эх" 2 одонтой эхчүүд	106000.0	1060	100235.0	1002
Ахмад дайчин, гавъяатын нэмэгдэл	4186.8	22	6969.8	20
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	20000.1	2939	29201.1	1591
ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт	7086.9	21	5767.8	49
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	57976.7	890	60163.0	844
ОНО-д түшиглэсэн халамжийн үйлчилгээ	-		6800.0	34
Бусад зардал	266.4		3956.3	

Тайлант хугацаанд 572 иргэнд 127.5 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 321 иргэнд 45.0 сая төгрөгийн тэтгэмж, 844 жирэмсэн эхчүүдэд 60.2 сая төгрөгийн тэтгэмж, ахмад дайчин, гавъяат цолтой 20 иргэнд 6.9 сая, алдарт эхийн одонтой 1595 эхчүүдэд 218.8 сая төгрөгийн нэмэгдэл, 1591 ахмад настанд 29.2 сая төгрөг, 49 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 5.7 сая төгрөгийн хөнгөлөлт, ОНО-д түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 34 иргэд 6.8 сая төгрөгийг тус тус олгосон байна.

НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ: 2014 оны эхний 2 сарын байдлаар нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын нийт орлого 209.7 сая төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.0 хувиар буюу 2.2 сая төгрөгөөр буурсан байна. Мөн нийт орлогын 109.7 сая төгрөг буюу 52.3 хувь нь хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 4. Орон сууц нийтийн аж ахуйн орлогын байдал

мянган төгрөг

Үзүүлэлт	2013 он	2014 он	Өсөлт бууралт
Орон сууц	67995.9	64032.8	-3963.1
Ус борлуулалт-бүгд	72195.8	73557.5	1361.7
үүнээс: хүн амд	46429.7	47519.6	1089.9
аж ахуйн нэгжид	24494.9	25214.7	719.8
үйлчилгээний байгууллагад	1271.2	823.3	-447.9
Сувагжуулалт	66193.4	66871.7	678.3
Бусад	5544.2	5244.7	-299.5
Дүн	211929.3	209706.7	-2222.6

Хүснэгт 5. СӨХ-дын орлогын байдал

мянган төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
Тавлаг өргөө	10413.9	9649.2	92.7
Маргад өргөө	8980.0	6886.2	76.7
Сод хөгжил	8126.9	9576.4	117.8
Шинэ элч	9477.9	7539.8	79.6
Уурхайчин	7168.0	5684.3	79.3
НИЙТ ДҮН	44166.7	39335.9	89.2

ЭРҮҮЛ МЭНД: Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээлснээр 2014 оны эхний 2 сарын байдлаар дүүрэгт 146 эх амаржиж, 147 хүүхэд төрүүлснээс гадны 21 эх амаржиж, 21 хүүхэд төрүүлсэн байна. Энэ оны эхний 2 сарын байдлаар 45153 хүн амбульторын үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 9714 хүнээр буюу 27.4 хувиар өссөн бол, 1157 хүн хэвтэн эмчлүүлснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 66 хүнээр буюу 5.4 хувиар буурсан байна.



Хүснэгт 6. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2013 он	2014 он	Өсөлт бууралт
Халдварт паразит өвчин	66	40	-26
үүнээс:			
Заг хүйтэн	28	12	-16
Тэмбүү	16	16	-
Трихомноз	12	9	-3
Кандидоз	4	-	-4
Сүрьеэ	6	3	-3

	Цочмог халдварт өвчин	55	13	-42
Үүнээс:	Цусан суулга	2	2	-
	Гепатит А	8	1	-7
	Салхин цэцэг	6	9	3
	Гар хөл амны өвчин	2	1	-1
	Гахайн хавдар	37	-	-37
	Нийт халдварт өвчин	121	53	-68


Зураг 8. Халдварт өвчин /сараар/



Оны эхний 2 сарын байдлаар халдварт паразит өвчний тохиолдол 40 болж, нийт халдварт өвчний 75.5 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 26 тохиолдлоор буюу 65.0 хувиар, цочмог халдварт өвчний тохиолдол 13 болж, нийт халдварт өвчний 24.5 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 42 тохиолдлоор буюу 76.4 хувиар тус тус буурсан байна.

ГЭМТ ХЭРЭГ: 2014 оны эхний 2 сарын байдлаар дүүрэгт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо 48 байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар буюу 3 хэргээр өссөн байна. Мөн хэрэг илрүүлэлт 50.0 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 33.3 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 9. Бүртгэгдсэн гэмт хэрэг /сараар/



Хүснэгт 7. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	Хэргийн тоо		Хэргийн өсөлт	Дүнд эзлэх хувь
	2013 он	2014 он		
Хүн амь	-	-	-	-
Хүчин	1	1	-	2.1
Дээрэм	2	2	-	4.2
Танхай	3	4	1	8.3
ББМГУчруулах	18	16	-2	33.3
Ашиглах	1	-	-1	-
Хулгай	10	11	1	22.9
<i>үүнээс: малын</i>	-	1	1	9.1*

Булаалт	-	-	-	-
Залилан	2	-	-2	-
ХАБЭсрэг	2	4	2	8.3
Гал түймэр	-	-	-	-
Бусад	6	10	4	20.8
Бүгд	45	48	3	100.0
Хэрэг илрүүлэлт	16.7%	50.0%		

*-малын хулгайн хэргийг нийт хулгайн хэрэгт эзлэх хувиар тооцсон.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн бүтцийг авч үзэхэд 2.1 хувийг хүчингийн хэрэг, 4.2 хувийг дээрмийн хэрэг, 8.3 хувийг танхай хэрэг, 33.3 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах /ББМГУчруулах/ хэрэг, 22.9 хувийг хулгай хэрэг, 8.3 хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг /ХАБЭ/ гэмт хэрэг, 20.8 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Оны эхний 2 сарын байдлаар хүн амь, ашиглах, булаалт, залилан болон гал түймрийн хэргүүд гараагүй байна.

Хүснэгт 8. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2013 он		2014 он	
	согтуугаар	гудамж талбайд	согтуугаар	гудамж талбайд
Хүчин	-	-	-	1
Дээрэм	1	1	2	1
Танхай	3	2	3	-
ББМГУчруулах	13	3	9	4
Хулгай	2	-	-	-
Залилан	-	1	-	-
ХАБЭсрэг	-	-	1	-
Бусад	2	-	3	4
Бүгд	21	7	18	10
Дүнд эзлэх хувь	46.6	15.5	37.5	20.8

Зураг 10. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг



2014 оны эхний 2 сарын байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 18 болж өнгөрсөн оны мөн үеэс 14.3 хувиар буюу 3 хэргээр буурсан байна. Энэ нь тайлант хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн 37.5 хувийг эзэлж байгаа бөгөөд нийт гэмт хэрэгт эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 9.1 пунктээр буурсан байна.

Мөн гудамж талбайд үйлдэгдсэн хэргийн тоо 10 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 42.8 хувиар буюу 3 хэргээр өссөн бөгөөд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 20.8 хувийг эзэлж байгаа нь өнгөрөгч оноос 5.3 пунктээр нэмэгдсэн үзүүлэлт юм.


БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД: 2014 оны 2 сарын байдлаар дүүрэгт ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй иргэд 272 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 29.2 хувиар буюу 112 хүнээр, эмэгтэй ажилгүй иргэд 137 байгаа нь өмнөх оны мөн үеэс 35.4 хувиар буюу 75 хүнээр тус тус буурсан байна.

Зураг 11. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн



Тайлант сард ажил идэвхтэй хайж байгаа 48 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүний 35.4 хувь нь буюу 17 нь эмэгтэйчүүд байна.

Зураг 12. Бүртгэлтэй ажилгүй иргэн /насны бүлгээр/



- 16-24 насны бүлэг ■ 25-34 насны бүлэг
- 35-44 насны бүлэг ■ 45-60 насны бүлэг

Тайлант сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа иргэдийг насны ангиллаар авч үзэхэд 16-24 насны ажилгүй иргэд 68 буюу 25.0 хувь, 25-34 насны ажилгүй иргэд 95 буюу 34.9 хувь, 35-44 насны ажилгүй иргэд 52 буюу 19.1 хувь, 45-60 насны ажилгүй иргэд 57 буюу 21.0 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 9. Ажилгүй иргэд, боловсролоор

Үзүүлэлт	Ажилгүй иргэд		Бүгдэд эзлэх хувь		
	2013 он	2014 он	2013 он	2014 он	
Бүртгэлтэй ажилгүй иргэд	384	272	100.0	100.0	
Үүнээс	Дээд	94	90	24.5	33.1
	Тусгай дунд	23	22	6.0	8.1
	Мэргэжлийн анхан шатны	25	21	6.5	7.7
	Бүрэн дунд	199	113	51.8	41.5
	Бүрэн бус дунд	37	20	9.6	7.4
	Бага	6	2	1.6	0.7
	Боловсролгүй	-	4	-	1.5


Зураг 13. Бүртгэлтэй ажилгүй иргэд /боловсролоор/



2014 оны 2 сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр ангилж үзэхэд 33.1 хувийг дээд, 8.1 хувийг тусгай дунд, 7.7 хувийг мэргэжлийн анхан шатны, 41.5 хувийг бүрэн дунд, 7.4 хувийг бүрэн бус

дунд, 0.7 хувийг бага боловсролтой 1.5 хувийг боловсролгүй ажилгүй иргэд эзэлж байна.


ҮНЭ ХАНШ: Өргөн хэрэглээний 18 төрлийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд 4 нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ тогтвортой, 3 нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ буурсан, 11 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнэ өссөн байна.



Хүснэгт 10. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний дундаж үнэ /жил бүрийн 2 сар/

Барааны нэр төрөл	Х\н	2010	2011	2012	2013	2014	2014% 2013
Гурил /дээд/	кг	690	875	950	971	1100	113.3
Гурил 1-р зэрэг /алтан тариа/	кг	575	750	750	765	765	100.0
Гурил 2-р зэрэг /алтан тариа/	кг	520	625	525	600	588	98.0
Цагаан будаа	кг	1400	1650	1600	1650	2200	133.3
Шар будаа	кг	1062	1725	1500	1450	1500	103.4
Хонины мах	кг	3194	4075	5656	6988	7125	102.0
Үхрийн мах	кг	3688	4875	6725	8000	8744	109.3
Сүү	л	1388	1200	1400	1563	1500	96.0
Тараг	л	1300	1400	-	-	-	-
Цөцгийн тос	л	3500	2900	3000	3000	3100	103.3
Элсэн чихэр	кг	1675	1700	1625	1600	1600	100.0
Монгол төмс	кг	850	875	900	700	700	100.0
Монгол байцаа	кг	1000	975	1000	1200	1200	100.0
Монгол лууван	кг	800	787	900	800	1200	150.0
Манжин	кг	800	1425	900	950	1500	157.9

Хятад бөөрөнхий сонгино	кг	1175	937.5	1000	1200	1400	116.7
Монгол сонгино	кг	1838	1500	2500	2950	1800	61.0
Ургамлын тос	ш	2638	2650	2850	3075	3575	116.3
Өндөг	ш	226	230	265	268	388	144.8



Хүснэгт 11. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2014 оны 2 сарын долоо хоногоор

Хүнсний бараа		х.н	2.07	2.14	2.21	2.28	<u>2.28%</u> 2.21	
"Алтан тариа" гурил	Дээд	кг	1100	1100	1100	1100	100.0	
	I зэрэг	кг	765	765	765	765	100.0	
	II зэрэг	кг	575	575	600	600	100.0	
Будаа	цагаан	кг	2200	2200	2200	2200	100.0	
	шар	кг	1500	1500	1500	1500	100.0	
Хонины мах	ястай	кг	6500	6500	6500	7000	107.7	
	цул	кг	7500	7500	7500	8000	106.7	
Үхрийн мах	ястай	кг	8000	8000	8000	8500	106.3	
	цул	кг	9250	9250	9250	9700	104.9	
Адууны мах, ястай		кг	6500	6500	6500	6500	100.0	
Ямааны мах		кг	6000	6000	6000	6000	100.0	
Элсэн чихэр		кг	1600	1600	1600	1600	100.0	
Сүү		литр	1500	1500	1500	1500	100.0	
Цөцгийн тос, Орос		кг	3100	3100	3100	3100	100.0	
Байцаа		кг	1200	1200	1200	1200	100.0	
Манжин		кг	1500	1500	1500	1500	100.0	
Төмс		кг	700	700	700	700	100.0	
Лууван		кг	1200	1200	1200	1200	100.0	
Сонгино	хятад	кг	1400	1400	1400	1400	100.0	
	монгол	кг	1800	1800	1800	1800	100.0	
Сармис, булцуу		кг	200	200	200	200	100.0	
Огурцы, хятад		кг	5000	5000	5000	5000	100.0	
Помидор, хятад		кг	5000	5000	5000	5000	100.0	
Ургамлын тос		ш	3575	3575	3575	3575	100.0	
Өндөг		ш	410	380	380	380	100.0	
Талх	буриад	900 гр	ш	1050	1050	1050	1050	100.0
		700 гр	ш	950	950	950	950	100.0
		500 гр	ш	800	800	800	800	100.0
	Есөн шанд		ш	800	900	900	900	100.0
	Атар талх		ш	850	850	850	850	100.0

Хүснэгт 12. Үйлчилгээний үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Үзүүлэлт	Айл өрх	ААНБ
Дулаан	1 м ² =341 төг	1м ³ =697 төг
Дулааны суурь тариф	40 м ² хүртлэх=3000 төг 40м ² - 80м ² = 5000 төг 80м ² –аас дээш = 10000 төг	-
Халуун ус	Өвөл 1 хүн=1282 төг /тоолуургүй/ 1м ³ =700 төг /тоолууртай /	1гкал=41147 төг
	Зун 1 хүн=1924 төг /тоолуургүй/ 1м ³ =1050 төг /тоолууртай /	
Цэвэр ус	1хүн=3243 төг 1м ³ =400 төг /тоолууртай/	1м ³ =590 төг тоолууртай 1м ³ =640 тоолуургүй
Бохир ус	1хүн=2967 төг 1м ³ =360 төг /тоолууртай/	1м ³ =590 төг тоолууртай 1м ³ =650 тоолуургүй

Хүснэгт 13. Цахилгааны үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
• Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
<i>Энгийн тоолууртай</i>		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	79.0
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	96.6
<i>2 тарифт тоолууртай</i>		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	84.0
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	60.0
<i>Сарын суурь тариф</i>	төг/сар	1000.0
• Аж ахуйн нэгж, байгууллага		
<i>Энгийн тоолууртай</i>		
	төг/квт.ц	105.6
<i>3 тарифт тоолууртай</i>		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	105.6
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	178.6
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	60.0

Хүснэгт 14. Түлш, шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2013 он	2014 он	өөрчлөлт	
			хувь	төгрөгөөр
АИ -76,80	1580	1540	2.5	-40
АИ -92,93	1710	1700	0.6	-10
Дизель түлш	1840	1830	0.5	-10

2014 оны 2 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд литр тутамдаа Аи-80 бензин 2.5 хувиар буюу 40 төгрөгөөр нэмэгдсэн бол, Аи-92 бензин 0.6 хувиар буюу 10 төгрөгөөр, дизель түлш 0.5 хувиар буюу 10 төгрөгөөр тус тус буурсан байна.

Зураг 17. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ /УБ-БН, БН-УБ/



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2014 оны 03 дугаар сарын 12